

**ГҮНСЭННОРОВ ВАН-ӨВӨР  
МОНГОЛЫН  
ШИНЭЧЛЭЛИЙГ ҮҮСГЭГЧ****Жагжид Сэчин (АНУ)**

Урианхай овгийн Гүнсэnnоровыг (1871—1930) орчин үеийн Монголын түүхэн дэх нэгэн жинтэй зүтгэлтэн хэмээн хэдүй хожуу ч гэсэн хүлээн зөвшөөрцгөөж байна. Их хувьсал өөрчлөлтийн үед улс төр, эдийн засгийн талаар тогтворгүй нутагт амьдарч байсан түүний бие Монголын дэвшил хөгжлийн төлөө эрчимтэй зүтгэж байжээ. Хэдийгээр тэрээр нийгэмд уршиг багатай аажмаар өөрчлөх замыг сонгож авсан боловч түүнийг хуучныг баримтлагчид, либерал үзэлтэн аль аль нь эсэргүүцэж байлаа. Хэдий тийм боловч хийсэн бүтээсэн зүйл, холыг харах чадвар нь түүнийг Монголын нэгэн их удирдагчийн байранд тавьж өгч байгаа юм.

Гүнсэnnоровын амьдрал үйлсийг үнэлэхэд түүний хүн ардынхаа төлөө хүчин зүтгэж байсан тухайн үеийн Хятад-Монголын харилцааны ертөнцийг ойлговоос зохилтой. Хоёр зуу гаруй жилийн турш Манжийн ноёрхол Монголын тал нутгийн амьдралыг тодорхойлсон үндсэн түүхийн хүчин зүйл болж иржээ. Манжийн эзэн хаад Монголыг нэгтгэхгүй байхыг хичээхийн хамт Монголын уламжлалт цэргийн хүчин чадлыг хэвээр хадгалан, ашиглаж байх зорилготой байв. Тиймээс ч манжчууд анхнаасаа монголын ард түмнийг хэсэгчлэн хуваахын зэрэгцээ феодалын засаглал хэрэгжүүлж өөртөө үнэнч байлгах хоёрдмол бодлого явуулжээ. Нэгэн зэрэг цагаан хэрмээр нэвтрэх соёлын солилцоог боогдуулж Монголын соёлыг хэвээр үлдээхийг оролдсон байна. Энэ бүгд нь дэлхийн ихэнх орон өөрчлөгдөн шинэчлэгдэж байх тэр үед Монголын эдийн засгийн болон сэтгэлгээний хөгжлийг чөдөрлөн барьж байлаа.

Манж Чин улс XIX зуунд шилжихийн сацуу түүний эрх баригчид хэдийнээ Хятадыг баримтлахгүй байж чадахгүй болж улам бүр хятадад идэгдэж иржээ. Үүнээс үүдэн монголчуудад найр талтай урьдын бодлого суларч XIX зуунд гадна дотнын даралт шахалт нэмэгдэхийн хамт хятад иргэдийг цагаан хэрмээс умарш нүүлгэн суулгахгүй байх тухай хорио зөрчигдөж зарим үед түүнийг бүр ч урамшуулах болов. Мөн энэ үед оросын нөлөө говийн ар нутагт түргэн ихэсч, Япон ч зүүн талд Манжуурын чигээр идэвхжиж ирэв. XIX зууны сүүл гэхэд хэд хэдэн хэсэгт хуваагдсан монголчууд хүчирхэг хөрш нарийнхаа түрэлт шахалтыг няцаах цэргийн болон бусад хүчээр туйлын дутмаг байлаа.

Нэгэн зэрэг хятад иргэд Монголын уламжлалт соёл, бэлчээр нутагт заналхийлж, манж нар ч дотоодын үймээн, гаднын даралт шахалтаас хүчин суларч байв. Ийм ээдрээтэй үед Гүнсэnnоров ван нарын хүмүүс олон улсын зөрчил тэмцэлд өртөгдөж болзошгүй Монголын сул талыг сайтар ухамсарлаж иржээ.

Гүнсэnnоровын төрсөн нутаг Зостын чуулганы Харчин баруун гарын хошуу бөгөөд энэ хошуу нь манж нартай холбоотон болсон монголын анхны хошуу нутгийн нэг болно. Харчин нутаг Бээжин, түүнчлэн Жэхэд байсан манжийн эзэн хааны зуны ордонд ойр дөт байлаа. Энэ нь нэг талаар давуутай боловч сүүлд хятад иргэдийн нүүдлийг хязгаарласан манжийн хориг сулрахын хамт ашиг муутайгаар эргэжээ. Энэ нь мөн салан тусгаарлах үзэлтэй монголчуудад Хятадын нөлөөний бүснээс ангижрахад бэрхшээл учруулж байв.

Гүнсээноров Харчины Вандүднамжил вангийн төрсөн ганц хүү төдийгүй эцгийнхээ манж хатнаас төрсөн «албан ёсны» хүү байсан юм. Бага залуудаа Гүнсээноров уламжлалт Монгол зан заншлаар хүмүүжигдэхийн хамт манжийн хориг саад суларч, эхийн нөлөө хүчтэй байсны үрээр хятад боловсрол олж авчээ. Энэхүү хос боловсрол нь түүнд монгол өв уламжлалаа үнэлэн цэгнэхийн зэрэгцээ мэдлэгийн хүрээгээ өргөтгөх бололцоо нээж өгсөн байна.

Эцгийн үжиг өвчин эмгэгийн улмаас идэр залуу Гүнсээноров хошуу засгийн ажлыг гүйцэтгэж иржээ. Тэр нь нүүн ирж суурьшсан хятад иргэд болон монголчуудын зөрчлийг зохицуулах аргагүй хатуу ширүүн цаг байлаа. Тухайлбал, 1891 онд гарсан хятадын Цзинь Тан тао үймээн Харчингийн хязгаар нутгийг түйвээсэн байна. Үүнээс гадна 1900 оны Ихэтуаны бослого, мөн 1894—1895 оны хятад-японы дайн нь Монголын статуст гүнзгий өөрчлөлт үзүүлж, залуу вангийн үзэл санаанд хүчтэй нөлөөлжээ.

1898 онд өөд болсон эцгийн орыг залгасан Гүнсээноров алба татвар, боловсролын шинэтгэл хийх замаар хошуу нутагтаа дэвшилтэт өөрчлөлт эхлүүлсэн байна. Тэрээр Манжийн эзэн хааны ордныхонтой нягт харилцаатай байсны улмаас түүний нэр хүнд Бээжинд өндөр байв. Гүнсээноров Ихэтуаны бослого дарагдахад төвийг сахиж, хэт даврагсад Харчин хошуунд орж ирэхэд хориг тавьжээ. Ихэтуаны бослогын дараахан вантан эзэн хаанд хандан үндэсний болон монгол захиргааны хүрээнд цэрэг, эдийн засаг, мөн боловсролын шинэтгэл хийхийг дэмжихийг хүсчээ. Хэдийгээр бослого хөдөлгөөн түүний төлөвлөгөөг хойш татсан боловч Хятадад өрнөдийн гүрнүүд өргөнөөр оролцох болсон нь Гүнсээноров ванд 1900 оноос хойш Харчинд шинэтгэл нэвтрүүлэх бололцоо олгожээ.

Гүнсээноров ван 1902 онд Монголд анхны орчин цагийн сургууль байгуулав. Нэлээд олон төрлийн хичээлтэй тэрхүү сургууль нь хуучныг баримтлагч монголчууд болон Бээжин шаргуу эсэргүүцэж байсан нөхцөлд яггүй амжилт байлаа. Вантан өөрийн шинэчлэлийн үзэл санааг хэрэгжүүлэх үүднээс АНУ-д очихыг завдаж байсан боловч чадсангүй. Харин тэрээр 1903 онд Японд очсоноор тэнд хүрсэн анхны монгол ван болсон байна. Японд Мэйжийн сэргэн мандалтын дараа авч хэрэгжүүлсэн шинэтгэл түүнийг ихээхэн зоригжуулж, Монголдоо буцаж ирсний дараа япон багш нар урьж авчран цэргийн сургууль болон охидын сургууль байгуулжээ. Ийнхүү 1900 оны эхээр Гүнсээноров ван хувийн эрх ашгийг огоорон хошуу нутагтаа боловсролыг хөгжүүлэхэд хүчин зүтгэж, зэргэлдээ хошууны ван гүн нар хүртэл түүнийг дагалдах болов.

Гүнсээноровын хатан болох Манжийн нөлөө бүхий Су вангийн охин дүү Шан-кунь түүний шинэтгэлийн арга хэмжээг идэвхтэй дэмжиж байжээ. Хэдийгээр сүүлдээ Гүнсээноров ван манжийн хаан ширээг сэргээх эсэх асуудлаар хатантайгаа санал зөрсөн боловч тэд хоёул шинэчлэл, боловсролыг хөхүүлэн дэмжихийн төлөө байлаа.

Хэдэн арван оюутан залуусыг Японд илгээснээр тэд дэвшилт үзэл төдийгүй техникийн боловсрол олж авчээ. Нутагтаа буцаж ирсний дараа тэд бусад олон монгол оюутанд нөлөө үзүүлж, дэвшилт үзэлтэй зарим нэг нь өөрсдийн ивээн тэтгэгч Гүнсээноровыг оролцуулан хуучныг баримтлагч монгол язгууртан нартаа дургүйцэх болов. Японд явж ирсний дараа Гүнсээноров ч хошуу нутагтаа тогтсон уламжлалт засгийн бүтцээ өөрчлөхийг хүсэж байжээ. Тэрээр Японы шинэчлэлийг үнэнхүү талархан дэмжигч байсан учир 1904—1905 оны

орос-японы дайны үед шууд ил бус ч гэсэн Японыг дэмжиж байлаа. Анхандаа түүний хошууны ноёд Оросын болон Японы гэж хоёр талд хуваагджээ. Явцан дунд Гүнсэnnоров вангийн байр суурь давамгайлж Японыг талархах бодлого баримталсан байна.

Манжийн эзэн хаан цагаан хэрмээс өмнөш нутагт өргөн шинэтгэл хийхээр хожимдсон хүчин чармайлт тавих болмогц Гүнсэnnоров ван Монголд хэрэгжүүлэх өргөн хүрээтэй төлөвлөгөө дэвшүүлжээ. Түүнд Монголын дотоод хэргээ захиран засах эрх мэдлийг өргөжүүлэх, алба татвар хураах болон орлогоо ашиглах орон нутгийн эрхийг нь өргөтгөх, боловсролыг хөхүүлж, монгол цэргийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, банк зээлийн систем нэвтрүүлэх зэрэг багтсан байна. Монголчуудын хүчийг бэхжүүлэх бус харин доройтуулахыг зорьж байсан Бээжингийн түшмэд нарын хувьд иймэрхүү дэвшилтэт төлөвлөгөө нийцэхгүй байв. Тухайлбал, тэдний нэг болох Яо Сыгуан хятад иргэдийг Монгол газар нүүлгэн суурьшуулж, Монголд хятадын эдийн засаг, улс төрийн оролцоог өргөтгөх замаар хошуу нутагт Манжийн эзэн хааны нөлөөг ихэсгэх төлөвлөгөө дэвшүүлсэн байна.

Яогийн үзэл бодол Гүнсэnnоровын төлөвлөгөөг үгүйсгэсэн уламжлалт Хятад төвийн үзлийн илрэл байлаа. Гүнсэnnоров вангийн төлөвлөгөө сэжиг төрүүлэх болсон учир 1905 онд Су вангаар тэргүүлсэн хянан байцаах хэсэг бүрдүүлж түүнийг Манжийн эзэн хаанд хир үнэнч эсэхийг магадлахаар илгээжээ. Азаар Су ван Гүнсэnnоровын хадам эцэг, нэгэн зэрэг хянах хэсгийн ахлагч болохын хувьд Гүнсэnnоровт хүлцэнгүй хандаж элдэв асуудал гарсангүй.

Манж Чин улсын сүүлчийн жилүүдэд Гүнсэnnоров ван Бээжинд шилжин очиж монголчуудад нааштай бодлого явуулах чиглэлд бүх цаг хугацаагаа зориулжээ. Тэрээр 1910 онд эзэн хааны ордны дэргэд дан монголчуудаар бүрдүүлсэн бие хамгаалах отряд байгуулах зөвшөөрөл олж авчээ. Үүнийгээ тэр нийслэлд нөлөөлж байх хэрэгсэл болгох бодолтой байсан боловч улс төрийн хуйвалдаан, мөн манжийн төр унаснаас болж хүссэн хүсэл нь биелсэнгүй.

1912 онд манжийн хааны ордонд болсон ширүүн маргаанд Гүнсэnnоров ван манжийн хааныг огцрохыг эсэргүүцэж хэрвээ засгийн эрхийг Хятадын бүгд найрамдах талынханд шилжүүлэх юм бол Өвөр Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцэх болно гэдгээ мэдэгдэж байв. Манжийн хаан ширээнээсээ буумагц тэрээр Харчинд буцан ирж Өвөр Монголын тусгаар тогтнолын асуудлыг хэлэлцэхээр Улаанхадад бага хурал зарлан хуралдуулав. Нэгэн зэрэг тэрээр саяхан тусгаар тогтносон Ар Монголын нийслэл Өргөө өөд өөрийн элч Лувсанчойжирыг мордуулж Өвөр болон Ар Монголыг нэгтгэх боломж байгаа эсэхийг магадлахаар шийджээ.

Өргөөгийн засгийн газар бүх монголчуудыг нэгтгэх хүсэлтэй гэдэгт эргэлзээ үгүй байсан боловч сул дорой зохион байгуулалт, мөн тэнд олж мэдсэн олон асуудал Лувсанчойжирын итгэлийг алдагдуулж, урмыг хугалжээ. Түүнийг Өргөөгөөс эргэж ирэхээс өмнө Гүнсэnnоров ванг Бээжинд хүрч ирэхийг Юань Шикай цэргийн хүчээр далайлган шаардсан байна. Үүний хамт Монголыг нэгтгэх тухай найдлага талаар болсон юм. Учир нь Гүнсэnnоров ван иймэрхүү хөдөлгөөн гарах юм бол гол удирдагч болох ёстой байв. Түүнчлэн Бээжинд ойр оршдог, Японоос тусламж авах гэж эхэлж оролдоод бүтээгүй зэрэг бэрхшээлээс шалтгаалан Өвөр Монголын зүүн хэсгийг тусгаар тогтноулах гэсэн оролдлого бүтэлгүй болоход хүрчээ.

Бээжинд ирээд Гүнсэnnоров ван Юань Шикайд найдвар мохсон

боловч Хятадад нийт олны төлөө нийгэм байгуулах гэсэн Сунь Ятсен, түүний хүчин чармайлтыг талархах болов. Сунь Ятсен түүнийг шинээр байгуулсан Гоминьдан намынхаа гүйцэтгэх хорооны гишүүнээр томилсон байна. Ийнхүү шинэ бүгд найрамдах талынхантай холбогд соноор Гүнсэнноров болон эзэн хааны ширээнд удмынхаа хүнийг дахин залах бодолтой түүний хатан хоёрын харьцаа хурцдаж иржээ.

Умард Хятадад ноёрхож байсан Юань Шикай Гүнсэнноров ванг Бээжинд байрладаг Монгол-Төвдийн хэрэг эрхлэх газрын даргаар томилов. Энэ нь эрх мэдлээр хомс албан тушаал байсан бөгөөд Өвөр Монголын нөлөө бүхий удирдагчийг Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөнөөс салган холдуулах гэсэн Юань Шикайн сонирхолд нийцэж байлаа.

Гүнсэнноров ван эрх тушаалаа ашиглан Бээжинд монгол, төвд залуучуудад зориулсан сургууль байгуулах зөвшөөрөл засгийн газраас олж авчээ. Хэдийгээр засаг захиргаа үе үе солигдох, хөрөнгө мөнгө үл хүрэлцэх зэрэг олон тооны бэрхшээл тохиолдож байсан боловч Монгол-Төвдийн сургууль ирээдүйн Монголын олон удирдагчийг бэлтгэн гаргасан байна. Тэдний дундаас Буянт, Ли Юншин нар Өвөр Монголын Гоминьдан хөдөлгөөнийг удирдалцан сүүлдээ Нанкины засгийн газарт алба хаших болцгоосон бол Улаанхуу, Өлзий-Одсэр нар Өвөр Монголын коммунист хөдөлгөөний нэрт зүтгэлтнүүд болсон юм. Энэхүү сургуулийн олон төгсөгчид мөн 1933 оны Өвөр Монголын автономит хөдөлгөөнд идэвхийлэн оролцсон юм. Гэвч Гүнсэнноровын хувьд багагүй бэрхшээлтэй байлаа. Учир нь оюутнууд түүнээс илүү дэвшилт шинэтгэл явуулахыг шаардаж байсан бол хуучныг баримтлагчид түүнийг чөлөөтэй үзэл санаа нэвтрүүлэн Өвөр Монголд үймээнтэй, тогтворгүй байдал үүсгэж байна гэж буруушааж байжээ.

Дэлхийн I дайн Хятад болон Монголын хувьд чухал нөлөө үзүүлж, Япон бий болсон байдлыг ашиглан «21 шаардлага» гэгчийг гаргаж ирэв. Дараахан нь хятадын эсрэг Монголын Бавуужавын удирдсан нэлээд өргөн бослого 1913—1916 онд зүүн Монголд өрнөв. Мөн Юань Шикай тэр үеэр Хятадын эзэн хаан болох бүтэл муутай оролдлого хийжээ. Манжийн удирдагчид Японы «21 шаардлага» зэрэг гаднын хүчнээс Бээжинд тулгаж байгаа даралт шахалт хязгаар нутагт нь ноёрхож буй хятадын цэргийн эрхтэний хүчийг сулруулж өгнө гэж найдаж байв. Гэтэл бусад гүрний шаардлагаар Японы санаархал хорогдож, монголчуудын бослого болон Манжийн эзэн хааныг дахин сэргээх оролдлого аль аль нь амжилтад хүрсэнгүй. Энэхүү амаргүй үйл явдлын үеэр Гүнсэнноров ван улс төрийн нарийн мэдрэмжтэй байж төвийг сахих мэргэн байр суурь баримталсан байна.

Юань Шикай 1916 онд нас нөгчиж 1917—27 онд Бээжинд цэргийн эрхтэн нар удаа дараалан солигдов. Сунь Ятсен болон түүний Гоминьдан нарын Төв Хороо Кантонд шилжин байрлажээ. Хэдийгээр Гүн Сэнноров Бээжинд үлдсэн боловч өөрийн хэд хэдэн итгэлтэй хүмүүсээ өмнө зүгт явахад саад хийсэнгүй.

1919 оны 5 сарын 4-ний хөдөлгөөн, түүний радикал үзэл Монголын хуучныг баримтлагчид болон зүүн жигүүрийн хооронд хавчигдсан Гүнсэнноров ванд шинэ бэрхшээл учруулав. Тэдгээр зүүн жигүүрийнхний заримыг тэрээр өөрийн сургуульдаа бэлтгэж гаргажээ. Энэ нь түүний үлдэж буй амьдралынх нь туршид нэхэл дагал болсон асуудал байсан юм.

Түүнчлэн 1917 онд хаант Орос задран нурсанаар хятадууд дахин Ар Монголд түрж орж ирсэн боловч бардам сэхүүн Хятадын захиргаа монголчуудын дургүйцлийг төрүүлжээ. Өргөөгийн монгол удирдагчид

хятадын эсрэг тэмцэхийн тулд эхлээд цагаан, дараа нь улаан оросын тусламжийг эрсэн байна. 1921 онд Монгол Ардын Хувьсгалт нам байгуулагдаж, 1924 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг тунхаглажээ. Энэхүү шинэ бүгд найрамдах улс нь Өвөр Монголын либерал, шинэчлэлийн үзэлтэн болон хувьсгалчдын хувьд итгэл найдварын бэлэг тэмдэг байсан бол хуучныг баримтлагчдын хувьд айдас түгшүүрийн эх үүсвэр болж байлаа. Иймээс энэхүү хүчин зүйл тэдгээр хоёр хүчний хооронд байсан Гүнсэnnоровын байр суурийг улам бүр ганцаардахад хүргэж байв.

Зөвлөлтөөс 1920-иод онд Гоминьданд үзүүлж байсан тусламж Өмнөд Хятад дахь уг намын нөлөөг ихэсгэхийн хамт радикал үзэлтэй Буянт хятадын Гоминьдан болон МАХН-ын тусламжтайгаар 1925 онд Чуулалт Хаалганд Өвөр Монголын Ардын Хувьсгалт Намыг байгуулав. Тус нам түргэн хугацаанд нэр хүндийг олсон боловч хятадын цэргийн эрхтэн Фэн Юйсянтай холбогдсон байсан агаад удсан ч үгүй Өвөр Монголын баруун хэсэгт орогнол эрэхээс аргагүйд хүрчээ.

Хятадын бүгд найрамдах улс байгуулагдаж, цэргийн эрхтний эрхшээлд орсны дараа хятадын цэргийн эрхтэн болон түшмэд нар Өвөр Монголын атар газрыг ашиглан хятад иргэдэд худалдах замаар хувийн ашиг хонжоо хайх болов. Зарим ухвар мөчид монголын ноёд Монголын бэлчээр нутагт газар тариалан хөгжүүлэх гэсэн хятадуудтай хамтран ажиллав. Энэхүү хямралтай үеэр Гүнсэnnоров болон түүний санаа нэгтнүүд Бээжинд байсан дэвшилт ба хуучныг баримтлагч монголчуудыг дайчлан монголын газар нутгийг хагалж тариалахыг эсэргүүцсэн өргөх бичиг барьж Дуань Цижуй болон түүний засгийн газраас Монголд цэргийн эрхтэн нар эзэгнэж байгааг зогсоохыг шаарджээ. Энэхүү өргөх бичгийг Бээжингийн засгийн газар хүлээн авсан боловч Жан Золин болон бусад цэргийн эрхтэнд хориг тавьсангүй. Харин ч үүнээс болж умард Хятадын эрх баригчдын дотор Гүнсэnnоров ихээхэн муу нэртэй болов.

1928 онд Гоминьданы хүч умар зүгт давшиж Бээжинд орж ирэх үеэр Гүнсэnnоров гэр бүлийн хамт Тяньжин дахь гадаадын эзэмшил газарт дүрвэн очжээ. Энэхүү ялалтын дүнд Буянт Гоминьдан нам болон Нанкины засгийн газарт өндөр тушаалд тохоогдсон боловч монголчуудын өөртөө засах байдлыг хангах талаар юм хийсэнгүй гэж шүүмжлэгдсэн байна. Хятадын мужийн эрх баригчид Монголын хязгаар нутагт эзэгнэх нь хэвээр үргэлжилж, Монголын талаарх засгийн газрын бодлого ч нааштай өөрчлөгдсөнгүй. Иймд Гүнсэnnоровын нөлөөлснөөр үндэсний аядуу үзэлтэй залуу удирдагч Үнэнбуян Монголын төлөөлөгчдийг бүрдүүлж Өвөр Монголын өөртөө засахыг шаардахаар Нанкиныг зорьжээ.

Гүнсэnnоров Бээжинд 1929 онд эргэн ирсэн боловч энэхүү санасандаа хүрч чадаагүй эх оронч дараа жил нь нас нөгчжээ. Нанкины засгийн газар 1930 онд Монголын бага хурлыг зарлан хуралдуулж Монголын чуулган, хошуудын захиргааны хуулийг баталснаар Монголын орон нутгийн өөртөө захирах зарчмыг шинэ засгийн газар хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрсөн байна.

Гүнсэnnоров хоёр зууны зааг үеийн Монголын хамгийн дэвшилт удирдагчийн нэг байлаа. Тэрээр чадвартай зохион байгуулагч, төрийн зүтгэлтэн байсан төдийгүй утга зохиол, урлагт ч боловсорсон хүн байв. Тэр олон улсын болон дотоодын нөхцөл байдлыг ойлгохын хувьд тухайн үеийн ямар нэгэн Монголын удирдагч, мөн Хятадын олонхи

удирдагчаас хол давуу байжээ. Харамсалтай нь түүний амьдарч байсан үед харгис хүчин хэт хүч нөлөөтэй байсан учраас түүний баримталж байсан дэвшилт үзэл жам ёсоор аажмаар хэрэгжих нөхцөлгүй байсан юм. Тэдгээр харгис хүчнийг зайлуулсны дараа ч урт удаан нийгмийн өөрчлөлт Гүнсэнноров вангийн хүсэж байсан тайван шинэтгэл биш харин огцом хувьсгалын хэлбэрээр өрнөсөн билээ. Хэрвээ нөхцөл байдал өөрөөр эргэсэн бол Гүнсэнноров хүн ардынхаа итгэл хүлээсэн удирдагч болж чадах байв. Гэвч тэрээр амьдралынхаа ихэнх хугацаанд Монголын либерал үзэлтэн болон хуучныг баримтлагчид аль алины шүүмжлэлд өртөх тавилантай байжээ.

Англи хэлнээс орчуулсан **Ц. Батбаяр**